



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/195

Хэрлэн сум

Дотоод аудитын хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, 69 дүгээр зүйл, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.12, 4.13, Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дотоод аудитын үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, түүний дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд явуулсан аудитын тайланг хэлэлцэх, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагаанд зөвлөгөө дэмжлэг үзүүлэх Дотоод аудитын хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Аймгийн Засаг дарга, Төсвийн ерөнхийлөн Захирагч

Гишүүд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хяналт дүн шинжилгээ, хууль эрхзүйн хэлтсийн дарга
Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төсөв санхүүгийн хөгжлийн хорооны дарга
Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга
Хяналт дүн шинжилгээ үнэлгээний хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны Ахлах мэргэжилтэн

Хараат бус гишүүн: Х.Гонгор Хэрлэн сумын өндөр настан

2. Дотоод аудитын хороо нь үйл ажиллагаандаа Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийг мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.

3. Уг захирамж гарсантай холбоотой аймгийн Засаг даргын 2022 оны 2 дугаар сарын 24-ний А/101 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

23101-517